

## ЗХУ байгуулагдсаны 25 жилийн ойг Монгол улсад тэмдэглэнэ

**12 дугаар сарын 8-ны өдөр, пүрэв гаригт 17.00 цагт Санкт-Петербургийн хөгжмийн ордон болон Россотрудничество Улаанбаатар хотод болох «Ур чадварын эзэд»-ийн хамтын төслийн концертод урьж байна, энэхүү тоглолт нь Тусгаар улсуудын хамтын нөхөрлөлийн 25 жилийн ойд зориулагдан зохион байгуулагдаж байна. Үзэгчдэд зориулж Оросын шинжлэх ухаан соёл урлагийн төвд Маринский театрын Залуучуудын найрал хөгжмийн Брасс-квинтет тоглоно.**

Брасс-квинтет уран сэтгэмж ашиглан хөгжмийн жинхэнэ шуургийг дэгдээнэ. Үзэгчид америк иргэн Дэвид Болдуины буулгасан **Вивальдигийн** ля минорийн алдарт *Концертийг* сонсох болно. Оросын ардын аман зохиолчдын баатрууд Москвагийн орчин үеийн хөгжмийн зохиолч **Олег Обловын** “Үлгэрийн дүр төрх”-өөр гарч ирнэ. Үдэшлэгт ирсэн зочид энэхүү чуулгад тусгайлан бичигдсэн **Виктор Эвальд ба Малкольм Арнольдын** Квинтетийг сонсох болно.

**Маринский театрын Залуучуудын найрал хөгжмийн брасс-квинтет хамтлаг** 2016 онд Петербургийн Дуу хөгжмийн их сургуулийн докторын зэрэг горилогч Игорь Яковлевийн снаачлагаар байгуулагдсан. Хамтлагт: Алексей Попов (бүрээ), Николай Странатковский (бүрээ), Михаил Винницкий (татах бүрээ), Захар Кацман (угалзан бүрээ), Евгений Бородавко (их бүрээ). Хамтлаг – Маринский театрын коцертний оролцогчид. 2016 онд энэхүү хамт олон Бүх Оросын “Мөнгөн дуу” (Петрозаводск) уралдаан наадамд шагналтан мөн Бүх Оросын хөгжмийн шагналтан болж байсан (Москва). Энэхүү тэмцээнд Захар Кацман (угалзан бүрээ) гоцлол хөгжимчнөөр шагнал хүртсэн.

**Улаанбаатар хотын Оросын шинжлэх ухаан, соёл урлагийн төв**

Эхлэл 17.00

Хаяг: Улаанбаатар, 12 микрорайон, Токиогийн гудамж, 39-р байр

Утас.: (976-11) 458682

«Ур чадварын эзэд» нь Санкт-Петербургийн хөгжмийн ордон ба “Россотрудничество” – ийн цорын ганц давтагдашгүй төсөл бөгөөд 2012 оноос эхлэн явагдаж байгаа ба Оросод тэргүүний хөгжимчдийн бүтээлч уулзалтыг хийж мөн гадаад орнуудын Оросын шинжлэх ухаан, соёл урлагийн төвүүдэд залуу шинэ үеийн гоцлогчдийн аялан тоглолтыг зохион байгуулдаг. **Төслийн анхны концерт Улаанбаатар хотод 2015 оны 11 сард зохион байгуулагдсан.**

Санкт-Петербургийн хөгжмийн ордон нь — *холбооны соёлын байгууллага ба 2006 онд оросын залуу хөгжимчдийг олон улсын тэмцээн наадамд бэлтгэх зорилгоор үүсгэн байгуулагдаж байсан. Энэхүү байгууллага нь Мойка, 122 гудамжинд байрлах Агуу жонон Алексей Александровичийн ордонд байрладаг. Уран сайхны удирдаач нь алдартай морин хийлч, Оросын ардын жүжигчин Сергей Родулгин юм.*

Дэлгэрэнгүй мэдээллийг: [www.spdm.ru](http://www.spdm.ru) сайт дээр харж болно.